



ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 4/04

Улаанбаатар хот

Монголын стратиграфийн комиссын бүрэлдэхүүнийг томилох тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А-306 дугаар тушаал, 2022 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн А-87 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын стратиграфийн комиссын даргаар Доктор (Sc.D) Я.Ариунчимэгийг томилсугай.
2. Монголын стратиграфийн комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, түүний ажиллах дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Албаны даргын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/22 дугаартай тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (С.Шинэ-Од)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРДОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.УЯНГА



Үндэсний геологийн албаны даргын 2023 оны
02 дугаар сарын 24-ны өдрийн 4/04 тугаар
тушаалын хавсралт 1

МОНГОЛЫН СТРАТИГРАФИЙН
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

№	Нэр	Эрдмийн зэрэг цол	Хариуцсан чиглэл
Дарга, орлогч дарга, нарийн бичиг			
1	Я.Ариунчимэг	Доктор (Sc.D), Дарга	Силур, Карбон Перм
2	Ж.Ундаръя	Доктор (Ph.D), Орлогч дарга	Мезозой
3	Р.Болд-Эрдэнэ	Магистр,	Нарийн бичгийн дарга
Зөвлөх			
4	О.Гэрэл	Доктор (Sc.D)	Магмын чулуулаг
5	Ж.Бямба	Доктор (Sc.D)	Тектоник
6	Д.Доржнамжаа	Доктор (Sc.D)	Метаморф чулуулаг
7	Р.Барсболд	Доктор (Sc.D)	Палеонтологи
8	Д.Оролмаа	Доктор (Ph.D)	Вулканоген чулуулаг
Гишүүд			
9	Б. Уянга	Доктор (Ph.D)	Урьдкембри, кембри
10	Г. Сэрсмаа	Доктор (Ph.D)	Кембри, Ордовик, Девон
11	Л. Уранбилэг	Доктор (Ph.D)	Перм, Триас
12	З. Бадамхатан	Доктор (Ph.D)	Юра, Цэрд
13	Л.Гэрэлцэцэг	Доктор (Ph.D)	Палеоген, Неоген
14	Ц. Наранцэцэг	Доктор (Ph.D)	Кайнозой
15	Н. Ичинноров	Доктор (Ph.D)	Мезозойн үр тоосонцор
16	С. Хишигсүрэн	Доктор (Ph.D)	Геодинамик
17	О. Жавхлан	Доктор (Ph.D)	Метаморф чулуулаг
18	Н.Манчук	Доктор (Ph.D)	Радиоляр судлал
19	Т.Оюунчимэг	Доктор (Ph.D)	Магматизм, офиолит эвшил

МОНГОЛЫН СТРАТИГРАФИЙН КОМИССЫН
АЖИЛЛАХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монголын стратиграфийн комисс /цаашид "Комисс" гэх/ нь Монгол орны нутаг дэвсгэрт ялгагдсан стратиграфийн нэгжийг баталгаажуулах, олон улсад дүйцүүлэх, түүнд Монгол Улсыг төлөөлөх эрх бүхий мэргэжлийн бөгөөд байнгын үйл ажиллагаатай байна;

1.2. Комисс нь Үндэсний геологийн алба /ҮГА-ны дэргэд орон тооны бус хэлбэрээр үйл ажиллагаа явуулах бөгөөд холбогдох хууль, тогтоомж болон энэ дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

Хоёр. Комиссын бүтэц, зохион байгуулалт

2.1. Комисс нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, байнгын болон түр гишүүн, зөвлөхөөс бүрдэнэ;

2.2. Комиссын бүрэлдэхүүн ажиллах хугацаандаа ҮГА-тай мэдээлэл нууцлалын гэрээ байгуулсан байх ба комиссын бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөнөөс хойш гэрээнд хамаарах заалт 3 жил хүчинтэй үргэлжилнэ;

2.3. Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажлын зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа гүйцэтгэгчээс тухайн төсөлд асуудал шийдвэрлүүлэхээр ирүүлсэн хүсэлтэд Комиссын удирдлагууд зөвшилцөн гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг, гишүүн болон түр гишүүдийг томилон ажиллуулна;

2.4. Хувийн хөрөнгөөр геологи-хайгуулын ажил гүйцэтгэгчээс асуудал шийдвэрлүүлэх хүсэлт ирсэн тохиолдолд Комиссын удирдлагууд зөвшилцөн холбогдох гишүүдийг томилон ажиллуулах ба ажлын хөлсийг захиалагч талтай тухай бүр зөвшилцөн шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд захиалагч тал хүсэлт гаргавал тодорхой хугацаанд нууцлалын гэрээ байгуулан ажиллах ба ажлын үр дүнг ҮГА-д тайлагнах үүрэг хүлээхгүй боловч уг мэдээллийг ҮГА-ны үндэсний геологи, эрдэс баялгийн сангийн стратиграфийн төрөлжсөн санг баяжуулахад ашиглаж болно;

2.5. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайланд Комиссоос дүгнэлт, зөвлөмж гарган Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд эцэслэн танилцуулна;

2.6. Тухайн төсөлд холбогдох геологийн бичвэр, зурган мэдээллийг төсөл гүйцэтгэгч нь комиссын нарийн бичгийн даргаар дамжуулан (зөвхөн цаасан хэлбэрээр) ирүүлнэ. Комиссын удирдлагууд зөвшилцөн тухайн асуудлыг хариуцсан гишүүд, эсхүл ажлын хэсэгт хуваарилан дүгнэлт гаргуулж нэгтгэнэ;

2.7. Комиссын хурлыг улирал тутам /шаардлагатай үед тухай бүр/-д хийх ба нийт гишүүдийн 2/3 хувь оролцсон нөхцөлд хурлыг хүчин төгөлдөрт тооцно. Хурлаар хэлэлцэж буй асуудлаар хуралд оролцсон 2/3-аас доошгүй гишүүдийн саналыг үндэслэн албан бичгийн хэвлэмэл хуудас ашиглан шийдвэр гаргана. Гишүүд тухайн жилд зохион байгуулагдсан комиссын хуралд 70%-аас доош ирцтэй оролцсон тохиолдолд комиссын гишүүнээс түдгэлзүүлэх үндэслэл болох ба комиссын хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ;

2.8. Комиссын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ҮГА нь Комиссыг /1/ тухайн жилд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн болон төсөлд хамаарагдах шийдвэрлэвэл зохих

геологийн асуудлуудын мэдээ, мэдээллээр хангах, /2/ хуралдаан явуулах байр болон бусад нөхцөлөөр дэмжиж ажиллана;

2.9. Комисс нь үйл ажиллагаагаа УГА-ны шууд удирдлага дор явуулах ба хагас жилд болон жилийн эцэст гүйцэтгэсэн ажлаа зөвхөн түүнд тайлагнана;

2.10. Комиссын гишүүн өөрийн хүсэлтээр болон хүндэтгэн үзэх шалтгаанаар цаашид ажиллах боломжгүй болсон тохиолдолд үйл ажиллагааг хэвийн явуулах үүднээс гишүүнийг комиссын хуралдаанаар хэлэлцэн мэргэшлийн дагуу нөхөн сонгож болно.

2.11. Түр гишүүдийг Үндэсний геологийн албаны даргын тушаалаар томилж, чөлөөлөх бөгөөд тухайн түр гишүүнтэй хөдөлмөрийн гэрээг холбогдох хууль тогтоомжийг дагуу байгуулж, ажиллана.

Гурав. Комиссын гүйцэтгэх ажлын хүрээ

3.1. Монгол Улсын хэмжээнд стратиграфийн нэгж ялгах, харьцуулах, насыг тогтоох, нэр өгөх гэх зэрэгт баримтлах Монголын стратиграфийн кодексыг батлан гаргана;

3.2. Батлагдсан стратиграфийн ангиллыг региональ, бүс болон нутгийн (хроно, био, лито гэх мэт) стратиграфийн түвшинд судлаачдаар дагаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулна;

3.3. УГА-тай хамтран Үндэсний геологи, эрдэс баялгийн сангийн холбогдох төрөлжсөн сангуудыг бүрдүүлэн, баяжуулж хөтөлнө.

3.4. Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд тархсан төрөл бүрийн, бүх насны хурдас, чулуулгийн биетүүдийг ялгах, гарал үүсэл, нас, газарзүйн тархалтаар системчилсэн схем зохиох, түүнийг боловсронгуй болгох, нэгдсэн ангилал боловсруулах гэх зэрэг стратиграфийн судалгаатай холбогдолтой асуудлаар санал дэвшүүлнэ;

3.5. Монгол Улсын хэмжээнд хийгдсэн болон хийж буй геологийн судалгааны ажлын стратиграфийн судалгааны ажлуудын үр дүнг нэгтгэн эмхэтгэх, үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, сэдэвчилсэн судалгааны ажил гүйцэтгэхэд санал өгч оролцоно;

3.6. Монгол орны нутаг дэвсгэрт гүйцэтгэж байгаа 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил болон бусад геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайлан дахь стратиграфи, магматизм, тектоникийн бүлэг, холбогдох дүгнэлтэд шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж өгнө;

3.7. Геологийн судалгааны ажлын талаар олон улсад шинээр гарсан онол, арга, аргачлалыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэн, шинээр хэрэгжүүлэх төслүүдийн талбай ялгах болон ажлын даалгаврын төсөлд санал өгнө;

3.8. Энэхүү журмын 3.6 дахь заалттай холбоотой аливаа заавар, журам, дүрмийн төсөлд санал өгөх, боловсронгуй болгох санал дэвшүүлж хамтран ажиллана;

3.9. Үйл ажиллагааны чиглэлээр дотоод, гадаадад ижил үйл ажиллагаа бүхий байгууллагуудтай ажил төрлийн холбоотой хамтран ажиллана.

Дөрөв. Комиссын үүрэг, эрх

4.1. Комиссын дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүд нь төсөл гүйцэтгэгчдээс ирүүлсэн геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайланд дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэнэ;

4.2. Комиссын нийт бүрэлдэхүүн Монгол орны нутаг дэвсгэрт олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу хийгдэж байгаа геологийн сэдэвчилсэн судалгаа болон зураглал, ерөнхий эрлийн хамтарсан төслийн чанар, үр дүнд хариуцсан чиглэлийн дагуу мэргэжлийн зөвлөгөө өгч, зөвлөмж, дүгнэлт гарган, энэ дүрмийн 4.3-4.6 дахь заалтуудыг хариуцлагатайгаар гүйцэтгэнэ;

4.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа геологийн судалгааны ажлын явцад болон суурин боловсруулалтын үед санал, зөвлөмж өгөх зорилгоор хээр ажиллаж буй анги, хамт олонд

харилцсан чиглэлээр мэргэжлийн туслалцаа үзүүлэхээр томилолтоор ажиллана;

4.4. Геологийн өвөрмөц тогтоц, бүтэц бүхий газар нутгийг мэргэжлийн хүрээнд судалж тогтоох, улмаар улсын тусгай хамгаалалтад хамруулах асуудлаар санал дэвшүүлнэ;

4.5. Улсын болон олон улс, бүс нутгийн хэмжээнд стратиграфийн чиглэлээр геологичдын хурал, зөвлөгөөнийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах, дэмжиж оролцох тухайн жилийн ажлын үр дүнг танилцуулж, шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх аргачлалыг тодорхойлно;

4.6. Комиссын гишүүд геологийн судалгааны ажлын явцад стратиграфийн чиглэлээр үүссэн маргаантай асуудлыг судалж, комиссын нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэнэ;

4.7. Гүйцэтгэх ажлын хүрээнд хувийн хэвшлийн болон олон улсын санхүүжилттэй төслийг дангаар болон хамтран хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлж оролцох, захиалагч, хамтран гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, хэлэлцээрт тусгагдсан нууцалснаас бусад ажлын тайлан, дүгнэлт, санал, зөвлөмж зэргийн үр дүнг хэвлэн нийтлүүлнэ;

Тав. Санхүүжилт

5.1. Комиссын бүрэлдэхүүний цалин, үйл ажиллагааны зардлыг геологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын аргачлал, хяналтын дансанд төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Комисс нь үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн саналыг тухайн оны нэгдүгээр улиралд багтаан Үндэсний геологийн албаар хянуулж, төрийн захиргааны төв байгууллагаар батлуулан хэрэгжүүлнэ;

5.2. Комиссын зардал нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, байнгын гишүүд болон түр гишүүд, зөвлөхийн цалин, улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэгч нарт зөвлөгөө, зөвлөмж өгөх зорилгоор томилолтоор ажиллах үеийн зардал, үр дүнгийн тайланд дүгнэлт гаргах үйл ажиллагааны зардал, комиссын үйл ажиллагааг сурталчлах, хариуцсан чиглэлээр ном, товхимол гаргах, хэвлүүлэх зардал, бичиг хэргийн зардал, шаардлагатай тохиолдолд гадаад хамтын ажиллагаанд хамаарах зардал зэргээс бүрдэнэ;

5.3. Комиссын бүрэлдэхүүний цалинг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны ажилтай холбоотой үйл ажиллагаанд оролцохоор томилогдон ажилласан хугацаа, оролцоотой уялдуулан олгоно;

5.4. Энэ дүрмийн 5.3 дахь заалтыг баримтлан Засгийн газраас тогтоосон төрийн захиргааны болон шинжлэх ухааны байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээнд мөрдөж байгаа албан тушаалын зэрэглэл, цалингийн сүлжээний шатлалтай харгалзах үндсэн цалингаас комиссын дарга, орлогч дарга, гишүүд, зөвлөхөд 25 хувь, нарийн бичгийн даргад 30 хувиар тооцож НДШ, ХАОАТ-ийг хасаж олгоно;

5.5. Комиссын түр гишүүдтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний дагуу ажлын хөлсийг тооцож олгоно.

5.6. Комисс нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг жилийн эцэст Үндэсний геологийн албанд, тус алба нь нэгдсэн тайлан, холбогдох шийдвэрийг төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан хүргүүлнэ;